



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд зөвлөл  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Монгол Улс Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 76 дугаар тогтоолын хавсралтын 4.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны албан хаагчдын ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэх асуудлаар хянан шалгах, дүгнэлт гаргах, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх үүрэг бүхий “Ёс зүйн дэд зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

- Зөвлөлийн дарга: ИТХ-ын Ажлын албаны Удирдлага, зохион байгуулалтын хэлтсийн дарга
- Гишүүн: ИТХ-ын Ажлын албаны Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга
- Нарийн бичгийн дарга: ИТХ-ын Ажлын албаны УЗБХ-ийн Хүний нөөц, шагнал хариуцсан мэргэжилтэн

2.Зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж, тухай бүр тайлагнаж ажиллахыг Ёс зүйн дэд зөвлөл (Г.Ундрал)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (П.Баянбаатар)-нд даалгасугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР

D:/2025/Захирамж.docx  
1150207063